

СЭДЭВ 2



Бусадтай адилгүй сургууль...

Маргааш өглөө нь бяцхан ид шидтэнгүүд шидэт усны шалгалт авах анги руугаа жагсан орлоо. Урьдынх шигээ хүн бүр хичээлийн хөтөлбөрийн бүх найрлагаа сайн цээжилсэн эсэхдээ эргэлзсэн тайван бус байдал ноёлж байлаа. Ангидаа хамгийн ахмад нь болох миний хажууд суудаг охин л ганцаараа өөртөө итгэлтэй байв. Тэр бүгдийг цээжээрээ мэддэг бөгөөд иймэрхүү шалгалтыг нэг энгийн зүйлд тооцдог байлаа. Тэр хуруугаа гозойлгон ийнхүү асуув :

- Уучлаарай багшаа, бид хичээл тэмдэглэсэн дэвтэрээ харж болох уу ?
 - Охидуудаа, байр байрандаа сууцгаа ! Хурдалцгаа ! гэж багш захирангүй хэллээ. Нэг тогоон дээр нэг л хүүхэд суу, хоорондоо ярихыг хориглоно. За энэ шалгалтын сэдэв шүү! Та нар ном дэвтэрээ харалгүйгээр хүн инээлгэх шидэт ус бэлдээрэй ! Хөөе, та нар тэндт номоо хурдан хаа ! Чимээгүй ажлдаа ор, тэгээд дуусахаараа бэлдсэн шидэт уснаасаа бага зэргийг балгаж үр дүнг нь шалгацгаа. За эхэлцгээ !

Жилл Мэрфигийн " Бүтэлгүй шидтэн буюу Амандинь Малабул " зохиолоос



Дараачийн асуултанд тохирох зөв хариултыг хүрээлж хариулна уу

1) Энэ зохиолыг хэн бичсэн бэ ?

Амандинь Малабул

Жилл Мэрфи

багш

2) Яагаад энэ анги бусадтай адилгүй вэ ?

- *Сурагчид бага насных*
- *Багш нь их хатуу*
- *Сурагчид цөм ид шидтэй*

3) Сурагчид шалгалтны үеэр бие биелээ тусалж болох уу ?

Тийм

Үгүй

Бага зэрэг болно

4) Багш сурагчдаа шалгалтанд тэнцсэн эсэхийг яаж шалгадаг вэ ?

- *Сурагч инээж эхлэхэд*
- *Сурагч чимээгүй байвал*
- *Сурагч ярьж эхлэхэд*

...../2 +/2 +/2 +/2 + =/8